# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГСА-2025/004/НА-СТА-ОНА


Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2025 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Платиниум прогресс аудит” ХХК
Захирал: Ж.Баяртуул
Утас: 99066015, Цахим хаяг:platiniumprogessaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2025.02.17 № 15

танай ______________-ны № ______________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
"ИЛЧЛЭГ ШИВЭЭ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ДОРЖХАНД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

422502059

"

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.4 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 1/1/2024 | 2024/12/31 |
| А | Б | 1 | 2 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | | |
| 1.1.1 | Мөнгөн хөрөнгө | 73,342,1 05.69 | 13,248,4 97.08 |
| 1.1.2 | Дансны авлага | 87,962,5 75.34 | 52,806,2 67.70 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | | |
| 1.1.4 | Бусад богино хугацаат авлага | 824,2 00.05 | |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 119,402,5 23.04 | 139,578,6 75.14 |
| 1.1.20 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 281,531,4 04.12 | 205,633,4 39.92 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 2,357,817,6 77.21 | 2,637,228,0 03.08 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 47,901,3 88.81 | 37,777,5 25.17 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 2,405,719,0 66.02 | 2,675,005,5 28.24 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 2,687,250,4 70.14 | 2,880,638,9 68.16 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 116,4 49.99 | 3,698,8 29.16 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 7,317,4 10.00 | 0.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 111,107,5 19.96 | 12,631,4 63.02 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 1,841,5 42.97 | 0.00 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 120,382,9 22.92 | 16,330,2 92.17 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 1,605,395,3 93.01 | 1,889,775,5 62.55 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 1,605,395,3 93.01 | 1,889,775,5 62.55 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 1,725,778,3 15.93 | 1,906,105,8 54.72 |
| 2.3 | ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | | |
| | Өмч | | |
| 2.3.1 | Өмч: а) төрийн | 2,337,169,8 92.00 | 2,337,169,8 92.00 |
| 2.3.2 | б) хувийн | | |
| 2.3.3 | в) хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 754,897,8 65.25 | 754,897,8 65.25 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Өмчийн бусад хэсэг | | |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг, алдагдал | -2,130,595,6 03.04 | -2,117,534,6 43.81 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 961,472,1 54.21 | 974,533,1 13.44 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 2,687,250,4 70.14 | 2,880,638,9 68.16 |

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан** **/төгрөгөөр/**

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОНЫ ДҮН | ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН |
|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 |
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 819,021,6 69.68 | 927,908,9 72.18 |
| 2 | Борлуулалтын өртөг | 665,961,0 19.63 | 912,187,9 26.82 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 153,060,6 50.05 | 15,721,0 45.36 |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүний орлого | 13,3 10.27 | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 66,117,9 56.00 | 286,338,3 31.68 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 4,063,4 68.75 | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 201,281,7 67.87 | 216,278,7 98.58 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 400,0 00.00 | 1,983,6 00.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | -69,284,8 01.55 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 13,446,6 79.71 | 14,512,1 76.92 |
| 19 | Орлогын татварын зардал | 1,344,6 67.97 | 1,451,2 17.69 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 12,102,0 11.74 | 13,060,9 59.23 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдлагдал) | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 12,102,0 11.74 | 13,060,9 59.23 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| | Бусад олз (гарз) | | |
| 24 | Орлогын нийт дүн | 12,102,0 11.74 | 13,060,9 59.23 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан** **/төгрөгөөр/**

| Д/Д | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл | 2,337,169,8 92.00 | 754,897,8 65.25 | -2,142,697,6 14.78 | 949,370,1 42.47 |
| 2 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 2,337,169,8 92.00 | 754,897,8 65.25 | -2,142,697,6 14.78 | 949,370,1 42.47 |
| 4 | Тайлангийн үеийн цэвэр ашиг | | | 12,102,0 11.74 | 12,102,0 11.74 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,337,169,8 92.00 | 754,897,8 65.25 | -2,130,595,6 03.04 | 961,472,1 54.21 |
| 10 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 2,337,169,8 92.00 | 754,897,8 65.25 | -2,130,595,6 03.04 | 961,472,1 54.21 |
| 12 | Тайлангийн үеийн цэвэр ашиг | | | 13,060,9 59.23 | 13,060,9 59.23 |
| 17 | 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,337,169,8 92.00 | 754,897,8 65.25 | -2,117,534,6 43.81 | 974,533,1 13.44 |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОНЫ ДҮН | ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН |
|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 739,382,5 82.19 | 864,767,7 72.93 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 736,197,3 87.19 | 856,615,1 28.61 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 104,5 93.00 | 162,3 39.00 |
| | Бусад мөнгөн орлого | 3,080,6 02.00 | 7,990,3 05.32 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 688,731,7 81.29 | 926,262,9 81.54 |
| | Ажиллагчдад олгосон мөнгө | 236,920,9 81.00 | 344,256,1 31.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 84,869,5 74.74 | 112,043,1 48.88 |
| | Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө | 282,565,9 53.91 | 323,497,8 98.28 |
| | Татварын байгууллагад төлсөн | 26,044,5 62.61 | 71,283,5 74.07 |
| | Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | 337,3 50.00 | 1,401,6 00.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 57,993,3 59.03 | 73,780,6 29.31 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 50,650,8 00.90 | -61,495,2 08.61 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 13,3 10.27 | |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Хүлээн авсан хүүний орлого | 13,3 10.27 | |
| | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | | |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 13,3 10.27 | |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | | |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | | |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 50,664,1 11.17 | -61,495,2 08.61 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 22,340,6 44.52 | 73,342,1 05.69 |
| 6 | Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 73,342,1 05.69 | 13,248,4 97.08 |

## 3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 41,021.8 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 3,457.5 мянган төгрөгийн алдааг залруулсан байна. Нийт 37,564.3 мянган зөрчил илэрч 1 зөвлөмж өгч ажиллаа.

Тайлант оны аудитаар 3,457.5 мянган төгрөгийн залруулга хийсэн. Үүнд:

- Тайлант онд Санхүүгийн тайлантай холбоотой гарсан 3.000.0 мянган төгрөгийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртгийн зардалд тооцсон
- Тайлант оны 6 сард 1 албан хаагчийн НД-ийг 275.6 мянган төгрөг илүү, 11 дүгээр сард 1 албан хаагчийн НД-ийг 181.9 мянган төгрөг дутуу тус тус тайлагнасан

### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой**

*Илрүүлэлт*: Тайлант онд төлөвлөгдсөн орлогын төлөвлөгөө 37,564.3 мянган төгрөгөөр тасарсан.

Энэ нь Аймгийн засаг даргатай байгууллагын даргатай байгуулсан 2024 оны гэрээний хавсралтад заасан "Байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ББӨ-ийг бүртгэхдээ хамаарах зардлыг бүртгэхгүй байна. | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | 1 | 3,000.0 | | | | |
| НДШ-ийг 2 албан хаагчид зөрүүтэй тайлагнасан. | 1 | 457.5 | 1 | 457.5 | | | 1 | 457.5 | | | | |
| Дүн | 2 | 3,457. 5 | 1 | 457. 5 | 1 | 3,000.0 | 2 | 3,457.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орлогын төлөвлөгөө тасарсан | 1 | 37,564.3 | | | | | 1 | 37,564.3 | | | | |
| **Дүн** | **1** | **37,564.3** | | | | | **1** | **37,564.3** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |